

**МОНГОЛ УЛС БОЛОН АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН
САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 12 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасныг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр төслийн санхүүжилтээр баригдах эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийг дотоодын компани болон төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой эсэх, орон нутгийн онцгой байдлын салбарыг туулах чадвар сайтай машин механизмаар хангах эсэх, Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлага хангасан, цаг үеэ олсон хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, аймгуудад эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга барих төсөл, хөтөлбөр ямар шалгуураар сонгогдсон талаар, Баян-Өлгий аймагт хэрэгжих төсөл, хөтөлбөр байгаа эсэх, Баян-Өлгий аймагт сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангалттай бус байгааг, мөн багуудын Өрхийн эрүүл мэндийн төвийг өргөтгөхөд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, орон нутгийн дэмжлэгтэйгээр Чингэлтэй дүүрэгт шинээр барих, буулгах, засварлах шаардлагатай сургууль, цэцэрлэг, сургуулийн өргөтгөлийн асуудлыг шийдвэрлэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат зээлийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарах, хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн боловсролын салбарт хийх хөрөнгө оруулалтыг дэмжих, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийн тоо, үйлчилгээний чанарт анхаарах, сургууль цэцэрлэгийн барилга, тэдгээрийн гал тогоо болон үдийн хоол үйлдвэрлэлийн стандартыг нэг мөр болгон мөрдөх шаардлагатай байгаа талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, бэлэн Азийн хөгжлийн банк хооронд 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг